



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/256

Хэрлэн сум

Үхрийн арьс товруутах өвчнөөс  
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/107 тушаалын дагуу үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд эрсдэл бүхий Дадал, Норовлин, Баян-Овоо, Мөрөн, Хэрлэн сумдын бүх үхэр болон шинээр гарсан тугал, Баянхутаг, Баян-Адарга, Батноров сумын үхэр сүргийг хамруулан 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн, хүч машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газрын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Л.Батсайхан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 12 өдрийн .....  
А/256 дугаар захирамжийн хавсралт

Үхрийн арьс товруутах өвчний дархлаажуулалтын ажилд хяналт тавьж,  
хариуцан ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарь

Д/д	Сумын нэр	Хяналт тавьж ажиглах Онцгой комиссын гишүүдийн свог нэр	Албан тушаал
1	Баянхутаг	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
2	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
3	Дадал	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
4	Норовлин	Ч.Гантсгтох	Онцгой байдлын газрын хошууч
5	Батноров	Л.Өлзийбат	Улаан загалмайн хорооны дарга
6	Баян-Овоо	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
7	Мөрөн	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
8	Хэрлэн	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга